



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Дундговь-Ус” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/01/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Мандалговь хот  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох  
Утас: 70592439  
Цахим хаяг: [Munkhtogtokhr@audit.gov.mn](mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn)

Аудитын менежер: Т.Батсайхан  
Утас: 70592225  
Цахим хаяг: [Batsaikhant@audit.gov.mn](mailto:Batsaikhant@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Должинсүрэн  
Утас: 70593113  
Цахим хаяг: [Doljinsurend@audit.gov.mn](mailto:Doljinsurend@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

---

## АГУУЛГА

---

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	5
3. Аудитын илрүүлэлт.....	6
3.1 Албан шаардлага .....	6
3.2 Өгсөн зөвлөмж:.....	7
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	0

---

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ-УС ОНӨААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ Т.МӨНХБАЯР ТАНАА

2026.02.18 № 81  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 48,547,429.7 мянган төгрөг болж өмнөх оноос 4,073,145.0 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн ОНХО, ОНХС болон байгаль хамгаалах сангуудаас нийт 6,232,929.8 мянган төгрөгийн уурын зуух болон шугам сүлжээг шинэчилсэнтэй холбоотой байна. Уурын зуухны шинэчлэлтэй холбоотой зарим хөрөнгийн эвдрэл, доголдлоос болж тухайн байгууллагаас 134,673.5 мянган төгрөгийн засвар хийж, зардлаар тайлагнасан байна.

Уг үйл явдлыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

#### Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад байгууллагын санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулж, 1,401,780.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэн, төлбөрийн чадвар алдагдаад байна. Иймд тухайн байгууллагын удирдлага болон Төлөөлөн удирдах зөвлөлд өр төлбөрийг

4826050273

барагдуулж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр анхаарч ажиллах албан шаардлагыг хүргүүлэн ажиллаа.

Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		2025 оны 1-р сарын 1	2025 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	41,527,378.68	23,394,663.02
1.1.2	Дансны авлага	315,300,026.00	363,689,610.22
1.1.4	Бусад авлага	9,636,054.33	1,703,712.00
1.1.6	Бараа материал	850,152,593.33	683,381,129.60
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо		15,556,054.33
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,216,616,052.34</b>	<b>1,087,725,169.17</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	44,454,169,285.19	48,518,483,127.58
1.2.2	Биет бус хөрөнгө	20,115,399.20	28,946,532.56
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>44,474,284,684.39</b>	<b>48,547,429,660.14</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>45,690,900,736.73</b>	<b>49,635,154,829.31</b>
2.1.1.1	Дансны өглөг	582,347,683.20	693,408,836.16
2.1.1.2	Цалингийн өглөг		315,000.00
2.1.1.3	Татварын өр	335,036,596.70	588,009,216.57
2.1.1.4	НДШ - ийн өглөг	6,248,297.06	117,314,971.97
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		2,732,000.00
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>923,632,576.96</b>	<b>1,401,780,024.70</b>
2.1.2.1	Урт хугацаат зээл	11,173,537,620.43	11,695,814,393.63
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>11,173,537,620.43</b>	<b>11,695,814,393.63</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>12,097,170,197.39</b>	<b>13,097,594,418.33</b>
2.3.2	Өмч: - төрийн	28,091,986,395.14	28,091,986,395.14
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	15,449,157,774.34	15,449,157,774.34
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	(3,835,415,924.32)	1,764,653,441.67
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(6,111,997,705.82)	(8,768,237,200.17)
<b>2.3.11</b>	<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>33,593,730,539.34</b>	<b>36,537,560,410.98</b>
<b>2.4</b>	<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>45,690,900,736.73</b>	<b>49,635,154,829.32</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2025 оны 1-р сарын 1	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>2,690,444,226.38</b>	<b>3,310,532,173.52</b>
<b>2</b>	<b>Борлуулсан бүтээгдэхүүний өртөг</b>	<b>4,887,209,912.06</b>	6,457,389,609.20
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>(2,196,765,685.68)</b>	<b>(3,146,857,435.68)</b>
8	Бусад орлого	801,060,061.62	1,387,828,203.00
9	Зардлын дүн	270,735,343.47	897,210,261.66
10	Ерөнхий ба удирдлагын зардал	270,735,343.47	244,551,203.30
12	Бусад зардал		116,456,338.84
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		(522,276,773.20)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(13,925,946.32)
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(1,666,440,967.53)</b>	<b>(2,656,239,494.35)</b>
19	Орлогын татварын зардал		
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(1,666,440,967.53)</b>	<b>(2,656,239,494.35)</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал</b>	<b>(1,666,440,967.53)</b>	<b>(2,656,239,494.35)</b>
<b>27</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(1,666,440,967.53)</b>	<b>(2,656,239,494.35)</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээ	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	<b>НИЙТ ДҮН</b>
<b>2024 оны 12 дугаар сарын 31-</b>	28,091,986,395.14	15,449,157,774.34	(3,835,415,924.32)	(6,111,997,705.82)	33,593,730,539.34

ний үлдэгдэл					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(2,656,239,494.3 5)	(2,656,239,494.3 5)
Өмчид гарсан өөрчлөлт			5,600,069,365.99		5,600,069,365.99
<b>2025 оны 12 дугаар сарын 31- ний үлдэгдэл</b>	28,091,986,395.14	15,449,157,77 4.34	1,764,653,441.67	(8,768,237,200.1 7)	36,537,560,410.9 8

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2025 оны 1-р сарын 1	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>3,571,613,074.86</b>	<b>3,915,534,758.78</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,851,627,074.86	3,469,633,918.78
	Татаас, санхүүжилтийн орлого	719,986,000.00	445,365,300.00
	Бусад мөнгөн орлого		535,540.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлага (-)</b>	<b>3,544,642,698.21</b>	<b>3,843,156,001.44</b>
	Ажиллагчдад төлсөн	924,960,074.24	1,552,112,513.84
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	331,459,574.41	339,174,242.19
	Бараа материал худалдан авахад төлсөн	1,267,038,774.00	910,331,217.80
	Ашиглалтын зардалд төлсөн	367,072,585.74	520,073,701.34
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	239,168,866.50	185,491,411.33
	Татварын байгууллагад төлсөн	103,078,657.69	129,216,048.78
	Даатгалын төлбөрт төлсөн	150,000.00	8,121,695.00
	Бусад мөнгөн зарлага	311,714,165.63	198,635,171.16
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>26,970,376.65</b>	<b>72,378,757.34</b>
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>30,015,700.00</b>	<b>90,511,473.00</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	30,015,700.00	76,211,473.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		14,300,000.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(30,015,700.00)</b>	<b>(90,511,473.00)</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(3,045,323.35)</b>	<b>(18,132,715.66)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>44,572,702.03</b>	<b>41,527,378.68</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>41,527,378.68</b>	<b>23,394,663.02</b>

## 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2025 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Борлуулалтын орлого	4,192,054,100.0	4,698,360,376.5	506,306,276.5	112.1
2	ББӨ	6,546,784,500.0	7,354,599,870.9	807,635,370.9	112.3
3	Нийт ашиг	(2,354,730,400.0)	(2,656,239,494.3)	(301,329,094.3)	112.8
4	Ерөнхий удирдлагын зардал	321,765,500.0	244,551,203.3	(77,214,296.7)	76.0
5	Цалингийн сан	2,716,282,100.0	1,778,313,322.3	(937,968,777.7)	65.5

### 3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,172,028.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 324,844.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,562,181.6 мянган төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 285,002.6 мянган төгрөгийн 2 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

#### **Залруулсан алдаа:**

Аудитаар 324,844.6 мянган төгрөгийн дараах алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн. Үүнд:

1. Айл өрхөөс авах 253,664.6 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй.
2. Бараа материалыг шууд зардлаар бүртгэж, 180.0 мянган төгрөгийн өглөгийг зөрүүтэй тайлагнасан.
3. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 71,000.0 мянган төгрөгийн 2 бохирын машиныг шийдвэрлэн бүртгэхдээ буруу бүртгэсэн.

#### **Залруулаагүй алдаа:**

Аудитаар нийт 1,847,184.2 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 1,562,181.6 мянган төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 285,002.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн.

#### **3.1 Албан шаардлага**

- 3.1.1 Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 150,771.9 мянган төгрөгийн 52 нэр төрлийн үндсэн хөрөнгийг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6./эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/ ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1-д /Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ/;

- 3.1.2 Санхүүгийн тайлан дахь 9,629.7 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т (холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах) тус хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т (анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно), Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д (өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх), Төсвийн тухай хуулийн 6.4.8-д (төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх), 16.5.2-д (батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих);

- 3.1.3 Байгууллагын санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулж, 1,401,780.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэн, төлбөрийн чадварыг алдагдуулсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д (өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх), Төсвийн тухай хуулийн 6.4.1-д (Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах), 6.4.8-д (Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5.-д (дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах);

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1.4 Байгууллагын санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учирч, авлага болон дансны өглөгийг өсгөн, төлбөрийн чадвар алдагдсан байхад хяналт тавьж, арга хэмжээ авч ажиллаагүй.

Энэ нь Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 06 сарын 02 өдрийн хурлаар хэлэлцэн баталсан “Дундговь ус ОНӨҮГ” –ын дүрмийн 4.4 ТУЗ нь дараах эрх, үүрэг гүйцэтгэнэ. 4.4.2-д (Үйлдвэрийн газрын жилийн орлого, зардлын тооцоог хянаж, үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөг хэлэлцэж, үнэлэлт, дүгнэлт өгнө), 4.4.5 (Мөнгө, үнэт цаас, биет хөрөнгийн ашиглалт зарцуулалтад хяналт тавьж, хөндлөнгийн шалгалт, тооллого, аудит хийлгэх, зөрчил дутагдалд арга хэмжээ авах эрхтэй) Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д (өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх);

### **3.2 Өгсөн зөвлөмж:**

#### **3.2.1. Авлагын данстай холбоотой.**

##### Илрүүлэлт:

Айл өрхөөс авах 06 сараас дээш хугацаа хэтрэлттэй 234,332.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4.-т /нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;/, 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д /өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх/, Төсвийн тухай хуулийн 6.4.8-д /төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх/, 16.5.2-д /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/ заасныг, мөн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Авлагын үлдэгдлийг 50 хувь хүртэл бууруулах арга хэмжээ авч ажиллах, хариуг нотлох баримтын хамт Дундговь аймгийн Төрийн аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 02-ний дотор ирүүлэх.

#### **3.2.2 Авлагын данстай холбоотой.**

##### Илрүүлэлт:

ААНБ-аас авах 06 сараас дээш хугацаа хэтрэлттэй 50,670.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4.-т /нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;/, 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д /өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх/, Төсвийн тухай хуулийн 6.4.8-д /төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх/, 16.5.2-д /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;/ заасныг, мөн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Авлагын үлдэгдлийг 50 хувь хүртэл бууруулах арга хэмжээ авч ажиллах, хариуг нотлох баримтын хамт Дундговь аймгийн Төрийн аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 02-ний дотор ирүүлэх

#### **3.2.3 Хөрөнгийн данстай хэрэгжилттэй холбоотой.**

Хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгийг бүртгэлд тайланд тусгасан боловч бөөн дүнгээр бүртгэсэн.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 10.42-д /Үндсэн хөрөнгийг олж бэлтгэх, шилжүүлэх ажил гүйлгээг дараах байдлаар бүртгэнэ, (д) бусад төсвийн байгууллагаас шинэ үндсэн хөрөнгө хүлээн авах үед:

Дт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/

Кт Төсвийн байгууллага хоорондын гүйлгээгээр хүлээн авсан хөрөнгийн орлого:/ заасныг, мөн үнэлгээ ба хувиарлалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бөөн дүнгээр бүртгэсэн үндсэн хөрөнгийг нэр төрлөөр нь салгаж бүртгэх, зөвлөмжийн дагуу төлөвлөгөө боловсруулан батлуулан, хариуг нотлох баримтын хамт Дундговь аймгийн Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 25-ний дотор ирүүлэх.

Дээрх тэг үлдэгдэлтэй хөрөнгийг шийдвэрлэх албан шаардлага болон авлага барагдуулах 2 зөвлөмж нь тус байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлан хийсэн завсрын аудитаар өгөгдсөн бөгөөд хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Аудитаар илрүүлсэн залруулагдаагүй 1,847,184.2 мянган төгрөгийн зөрчлийн 91.3 хувь буюу 1,686,782.6 мянган төгрөгийн нийцлийн асуудал, 8.7 хувь 160,401.6 мянган төгрөгийн санхүүгийн аудитын зөрчил илэрсэн байна. Үүнээс завсрын аудитаар илэрсэн 150,771.9 мянган төгрөгийн санхүүгийн аудитын зөрчлийг жилийн эцсийн аудитаар зөрчлийг арилгасан тул санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 9,629.7 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 7.6 дахин бага тул “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Айл өрхөөс авах авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй.	1	253,664.6	1	253,664.6								
Бараа материалыг шууд зардлаар бүртгэж, өглөгийг зөрүүтэй тайлагнасан.	1	180.0			1	180.0						
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2 бохирын машиныг шийдвэрлэн бүртгэхдээ буруу бүртгэсэн.	1	71,000.0			1	71,000.0						
Дүн		<b>324,844.6</b>	<b>1</b>	<b>253,664.62</b>	<b>2</b>	<b>71,180.0</b>						

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 150,771.9 мянган төгрөгийн 52 нэр төрлийн үндсэн хөрөнгийг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй.	1	150,771.9			1	150,771.9							
Санхүүгийн дахь 9,629.7 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	9,629.7			1	9,629.7							

Хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгийг бүртгэлд тайланд тусгасан боловч бөөн дүнгээр бүртгэсэн.	1	0.0					1	0.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>160,401.6</b>			<b>2</b>	<b>160,401.6</b>	<b>1</b>	<b>0.00</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэй холбоотой зөрчил												
Дүн												
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Айл өрхөөс авах 06 сараас дээш хугацаа хэтрэлтэй 234,332.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй.	1	234,332.5			1	234,332.5						
ААНБ-аас авах 06 сараас дээш хугацаа хэтрэлтэй 50,670.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй.	1	50,670.1			1	50,670.1						
Байгууллагын санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулж, өр төлбөр үүсгэн, төлбөрийн чадварыг алдагдуулсан.	1	1,401,780.0			1	1,401,780.0						
Байгууллагын санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учирч, авлага болон дансны өглөгийг өсгөн, төлбөрийн чадвар алдагдсан байхад хяналт тавьж, арга хэмжээ авч ажиллаагүй.	1	-			1	-						
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>1,686,782.6</b>			<b>4</b>	<b>1,686,782.6</b>						
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>1,686,782.6</b>			<b>4</b>	<b>1,686,782.6</b>						

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>		<b>1</b>			<b>1</b>			